



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/750

Булган сум

**Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг. зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ;

1. Улсын болон орон нутгийн чанартай авто замын нөхцөл байдал хүндэрч, зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан, халтиргаа гулгаа үүсэх, цаг агаар хүйтэрсэн нөхцөлд мотоциклиор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, амь насанд учирч болох хор хохирол, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцохыг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал түр хугацаагаар хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг. зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын дарга. цагдаагийн дэд хурандаа (Г.Ганбаяр)-т даалгасугай.

3. Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүнг аймгийн Засаг даргад 2024 оны 4 дүгээр сарын 01-ний дотор танилцуулахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа (Г.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

